



III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ойн хөнөөлт шавж, өвчний хээрийн судалгаа, тэмцлийн ажилд хяналт мониторинг хийх ажлын гүйцэтгэгчийн үзүүлэх ажил үйлчилгээ нь Монгол орны ойн хомсдол, доройтлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх, ойн экосистемийн үйлчилгээг хамгаалж Монгол Улсын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэгдэнэ.

Зорилго: Хяналт мониторингийн ажил нь ойн хөнөөлт шавжийн биологийн онцлогтой уялдуулан хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд судалгаа, тэмцлийн ажлын зорилго, зорилтод нийцүүлэн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт мониторинг хийх явдал юм.

- Ойн хөнөөлт шавж, өвчний нарийвчилсан судалгаа хийх, суурин цэг байгуулах, ойн хөнөөлт шавжийн тархалт, голомтын байршил тогтоох судалгааны ажлын гүйцэтгэлд хяналт мониторинг хийх;
- Ойн хөнөөлт шавжтай агаарын хөлөг болон гэрлэн урхи, үүргэн шүршигч ашиглан тэмцэх, механик аргаар тэмцэх ажлын гүйцэтгэлд хяналт мониторинг хийх;
- Ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажилд агаараар болон газраар тэмцэх ажил гүйцэтгэх ажлын арга зүй, стандартыг мөрдөж ажиллах;
- Хөндлөнгийн хяналт, мониторингийн ажилд орон нутгийн оролцоог хангаж, хамтарч ажиллах;
- Ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа хийх, хөнөөлт шавжтай тэмцэх ажлын арга зүй, тэмцлийн ажлын арга хэлбэрийг судалж дүгнэлт гаргах, цаашид ажлын чанар үр дүнг нэмэгдүүлэх, дээшлүүлэх талаар зөвлөмж боловсруулж захиалагчид хүргүүлэх;
- Ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажлын биелэлтийг гаргах, дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлийн тайланг захиалагчид хүлээлгэн өгөх;

Ойн хөнөөлт шавж, өвчний нарийвчилсан судалгаа хийх, суурин цэг байгуулах, ойн хөнөөлт шавж, өвчний тархалт, голомтын байршил тогтоох судалгааны ажлын гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт мониторинг хийх ажлын хүрээнд доор дурдсан ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Ойн хөнөөлт шавж, өвчний төрөл зүйл, тархалт, голомт, байршил тогтоох, судалгаа хийх 1.4 сая.га талбайн 10 хувьд хяналтын тооллого хийж, судалгааны бодит байдлыг үнэлж дүгнэлт гаргах;

- Ойн хөнөөлт шавж, түүнтэй тэмцэх ажлын үр нөлөөг судалж экологид үзүүлэх нөлөөллийг тогтоох судалгааны ажлын гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт мониторинг хийх:
- Ойн хөнөөлт шавж, өвчний байршил, тархалт, голомт тодорхойлох судалгаа, суурин судалгааны ажлын үр дүнд үнэлгээ хийж алдаа зөрчлийг залруулах:

Ойн хөнөөлт шавжтай агаарын хөлөг болон үүргэн шүршигч ашиглан тэмцэх ажлын гүйцэтгэлд хяналт мониторинг хийх ажлын хүрээнд доор дурдсан ажлыг гүйцэтгэнэ: Үүнд:

- Ойн хөнөөлт шавжтай агаарын хөлөг ашиглан микробиологийн аргаар тэмцэл хийсэн нийт талбайн 10 хувьд хяналтын тооллого хийж ажлын үр дүнг үнэлэх:
- Ойн хөнөөлт шавжтай үүргийн шүршигч багаж ашиглан микробиологийн аргаар тэмцэл хийсэн нийт талбайн 10 хувьд хяналтын тооллого хийж тэмцлийн ажлын үр дүнг тооцох, үнэлэх:
- Агаарын хөлөг болон үүргийн шүршигч багаж ашиглан ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажил хийгдсэн талбайд 2-3 удаагийн давтамжтай хяналтын тооллого хийж үр дүнг тооцох:
- Ойн хөнөөлт шавжтай агаарын хөлгөөр тэмцэх ажлын нислэгийн багийн үйлчилгээнд үнэлгээ хийх, хяналт мониторинг хийж дүгнэлт гаргах:
- Ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажилд агаараар болон газраар тэмцэх ажил гүйцэтгэх ажлын арга зүй, стандартыг судалж, мөрдөх ажлын хүрээнд доор дурдсан ажлыг гүйцэтгэнэ:

Ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа, тэмцлийн ажилд дараах стандарт, аргазүйг мөрдлөг болгоно. Үүнд:

- Ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа, тэмцлийн ажлын хөндлөнгийн хяналт мониторинг хийх ажилд дараах стандарт, арга зүйг мөрдлөг болгон ажиллана. Үүнд: “Ойн хөнөөлт шавжтай микробиологийн аргаар тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага MNS 6535:2015”
- “Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд тавигдах ерөнхий шаардлага MNS 6532:2015”
- “Ойн хөнөөлт шавжтай механик аргаар тэмцэх ажилд тавигдах ерөнхий шаардлага MNS 6537:2015”
- “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүнг тооцох ажилд тавигдах ерөнхий шаардлага MNS 6534:2015”
- “Ойн хөнөөлт шавжийн тархалтыг тодорхойлох судалгааны ажилд тавигдах ерөнхий шаардлага MNS 6533:2015”
- Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцлийн ажлын үр дүнг тооцох арга зүй,
- Ойн хөнөөлт шавж, өвчний тархалт, голомтыг тогтоох арга зүй
- Ойн хөнөөлт шавжтай тэмцэл хийснээр шавжийн бүлгэмдэлд үзүүлэх нөлөөг мониторингоор судлах арга зүй

ХАВСРАЛТ № 1.

1. Ойн хөнөөлт шавжтай агаарын хөлөг ашиглан микробиологийн аргаар тэмцэх ажилд доор дурдсан газар нутаг хамаарна. Үүнд:

д/д	Аймаг нэр	Сумын нэр	Тэмцлийн ажил явуулах талбай (га)		ОЗБ хийсэн огноо	Зүйлийн нэр
			Агаарын хөлөг	Хэсэглэлийн дугаар		
Багц-1. Агаарын хөлөг ашиглан ойн хөнөөлт шавжтай тэмцэх						
1	Улаанбаатар хот	Ногоон бүс	6000	27,143, 144, 145,150,151, 152, 156, 157, 158, 160-162, 169,170,172,176,184,185, 73,74,118,117, 119, 113,114, 115,116,118,119, 120	2015	Сибирийн хүр, Якобсоны төөлүүрч эрвээхэй
2	Богдхан-уул ДЦГ		3000	58, 1, 2, 3, 4, 21, 6, 26, 11, 14, 15, 41, 69, 70, 71		Сибирийн хүр, Якобсоны төөлүүрч эрвээхэй
3	Горхи-Тэрэлж БЦГ		3000	725, 745, 767, 785, 786, 787, 806,807,808, 825, 826,173, 848, 865, 826, 866, 867, 851, 884, 868, 875, 888		Сибирийн хүр эрвээхэй, Якобсоны төөлүүрч эрвээхэй, Шилмүүс хуйлагч эрвээхэй
4	Төв	Эрдэнэ	4000	828, 859, 869, 872, 873, 875, 888, 891, 893, 898, 920, 926, 929, 930, 931, 932, 936		Якобсоны төөлүүрч эрвээхэй, Сибирийн хүр эрвээхэй, Шинэсний шилмүүс хуйлагч,
5	Архангай	Эрдэнэмандал	10000	38 /1-16/, 39 /1-15, 40/1-13/, 55 /1-7/, 60-62, 67-70, 41-43, 54-59, 63-66, 1-10	2017	Якобсоны төөлүүрч эрвээхэй, Эгэл бийрэн сүүлт эрвээхэй
Дүн			26000			
Багц-2. Агаарын хөлөг ашиглан ойн хөнөөлт шавжтай тэмцэх						
1	Архангай	Ихтамир	8000	130, 128, 100, 89, 88, 146, 110, 157, 150, 180, 106, 142, 143, 145, 125, 77, 75, 88, 97, 96, 107, 83, 105, 74	2017	Эгэл бийрэн сүүлт эрвээхэй, Якобсоны төөлүүрч эрвээхэй
2		Чулуут	8000	8, 5, 7, 2, 25, 26, 16, 62, 52, 46, 63, 57, 65, 74		
3	Өвөрхангай	Бат-Өлзий	20000	6, 25, 43-47, 48-51, 58-60,62, 63, 65-69, 73, 74, 78, 79, 80, 81, 84-86, 88, 95, 102, 103	2016	Эгэл бийрэн сүүлт эрвээхэй, Якобсоны төөлүүрч эрвээхэй
Дүн			36000			
Багц-3. Агаарын хөлөг ашиглан ойн хөнөөлт шавжтай тэмцэх						
1	Завхан	Их-Уул	5000	85, 87, 88, 86, 89, 90, 91, 92, 93	2013	Эгэл бийрэн сүүлт эрвээхэй, Якобсоны төөлүүрч эрвээхэй
2		Тосонцэнгэл	6000	30, 88, 89, 74, 75, 76, 90, 91, 92, 77, 78, 79, 80, 81, 82, 83, 84, 85, 86, 87, 93, 94, 95		
3	Увс	Баруунтуруун	3000	4,5,9,8,15,17,18,196,13	2020	Шилмүүс хуйлагч
4		Зүүнхангай	3000	29,30,31,35,36,28,27		Якобсоны төөлүүрч эрвээхэй, Шилмүүс хуйлагч

5		Өндөрхангай	7000	14,13,7,6,12,18,17,9 11, 16		Шинэсний шилмүүс хуйлагч
Дүн			24000			
Багц-4. Агаарын хөлөг ашиглан ойн хөнөөлт шавжтай тэмцэх						
1	Увс	Түргэн	5000	1-3, 5-24, 29-35, 37-49 бүх хэсэглэлийн бүх ялгаралд	2020	Якобсоны төөлүүрч эрвээхэй, эгэл бийрэн сүүлт эрвээхэй
2		Улаангом	1500	2- 10 бүх хэсэглэлийн бүх ялгаралд		
3	Хөвсгөл	Шинэ-Идэр	6000	19-24 ,61-64	2012	Якобсоны төөлүүрч эрвээхэй Якобсоны төөлүүрч эрвээхэй
4		Төмөрбулаг	6000	60 ,62 ,73 ,87, 90 ,106		
Дүн			18500			

2. Ойн хөнөөлт шавжтай үүргийн шүршигч багаж ашиглан микробиологийн аргаар тэмцэх ажилд доор дурдсан газар нутаг хамаарна. Үүнд:

д/д	Аймаг нэр	Сумын нэр	Тэмцлийн ажил явуулах талбай /га/		ОЗБ хийсэн огноо	Зүйлийн нэр
			Үүргийн шүршигч	Хэсэглэлийн дугаар		
Багц-2. Үүргийн шүршигч багаж ашиглан ойн хөнөөлт шавжтай тэмцэх						
1	Архангай	Эрдэнэмандал	2000	38 /1-16/, 39 /1-15, 40/1-13/, 55 /1-7/, 60-62, 67-70, 41-43, 54-59, 63-66, 1-10	2017	Якобсоны төөлүүрч эрвээхэй Якобсоны төөлүүрч эрвээхэй Эгэл бийрэн сүүлт эрвээхэй, Якобсоны төөлүүрч
2		Хайрхан	3000	1, 2, 3, 4, 5, 14, 13, 15, 16, 58, 47, 72, 70, 69, 62, 57, 7		
3		Өндөр-Улаан	6000	121, 122, 123, 124, 125, 126, 140, 141, 155, 156, 158 159		
Дүн			11000			
Багц-3. Үүргийн шүршигч багаж ашиглан ойн хөнөөлт шавжтай тэмцэх						
1	Хөвсгөл	Галт	3000	51,52, 57,59, 61,62,67-69, 76,88, 103-108 ,113-115 ,123	2012	Якобсоны төөлүүрч эрвээхэй Якобсоны төөлүүрч эрвээхэй Якобсоны төөлүүрч эрвээхэй, Шинэсний шилмүүс хуйлагч
2		Жаргалант	3000	2,6 ,7 ,11,13,14,18-21, 23 ,25 ,32 ,33,36 ,44-49 ,51-56 ,69, 71,77 ,81-85		
3		Рашаант	3000	22, 23, 24, 67,54,55,69		
4	Төв	Батсүмбэр	3000	81, 82, 90, 94, 104, 110, 106, 147, 187, 193, 202	2013	Сибирийн хүр эрвээхэй, Якобсоны төөлүүрч эрвээхэй
Дүн			12000			
Багц-4. Үүргийн шүршигч багаж ашиглан ойн хөнөөлт шавжтай тэмцэх						
1	Увс	Зүүнхангай	2000	29,30,31,35,36,28,27	2020	Якобсоны төөлүүрч эрвээхэй, Шилмүүс хуйлагч Шилмүүс хуйлагч Шинэсний шилмүүс хуйлагч
2		Өндөрхангай	2000	14,13,7,6,12,18,17,9 11, 16		
3		Баруунтуруун	2000	4,5,9,8,15,17,18,196,13		

4	Завхан	Сонгино	1000	1,2	2013	Якобсоны төөлүүрч эрвээхэй
5		Тэлмэн	3000	51-56		Якобсоны төөлүүрч эрвээхэй
Дүн			10000			

3. Ойн хөнөөлт шавж, өвчний нарийвчилсан судалгаа хийх, тархалт, голомтыг тогтоох судалгааны ажилд доор дурдсан газар нутаг хамаарна. Үүнд: Багц-1.

№	Аймгийн нэр	Сумын нэр	Судалгааны ажил явуулах төлөвлөгөө (га)	№	Аймгийн нэр	Сумын нэр	Судалгааны ажил явуулах төлөвлөгөө, га
1	Увс	Баруунтуруун	18000	4	Өвөрхангай	Хужирт	15000
2		Бөхмөрөн	9000	5		Бат-Өлзий	30000
3		Зүүнхангай	20000				
ДҮН			47000		ДҮН		45000
НИЙТ ДҮН					92000		

4. Ойн хөнөөлт шавж, өвчний нарийвчилсан судалгаа хийх, тархалт, голомтыг тогтоох судалгааны ажилд доор дурдсан газар нутаг орно. Үүнд: Багц-2

№	Аймгийн нэр	Сумын нэр	Судалгааны ажил явуулах төлөвлөгөө, га	№	Аймгийн нэр	Сумын нэр	Судалгааны ажил явуулах төлөвлөгөө, га
1	Төв	Батсүмбэр	33000	4	Улаанбаатар	Ногоон бүс	70000
2		Эрдэнэ	30000	5		Богд-Уул	20000
3		Горхи тэрэлж	15000				
ДҮН			78000		ДҮН		90000
НИЙТ ДҮН					168000		

5. Ойн хөнөөлт шавж, өвчний нарийвчилсан судалгаа хийх, тархалт, голомтыг тогтоох судалгааны ажилд доор дурдсан газар нутаг хамаарна. Үүнд: Багц-3

№	Аймгийн нэр	Сумын нэр	Судалгааны ажил явуулах төлөвлөгөө, га	№	Аймгийн нэр	Сумын нэр	Судалгааны ажил явуулах төлөвлөгөө, га
1	Архангай	Өндөр -Улаан	15000	6	Хөвсгөл	Галт	10000
2		Тариат	15000	7		Жаргалант	10000
3		Хайрхан	14000	8		Рашаант	15000
4		Чулуут	15000	9		Төмөрбулаг	10000
5		Эрдэнэмандал	20000	10		Шинэ-Идэр	10000
ДҮН			79000		ДҮН		55000
1	Завхан	Их-Уул	16000	3	Завхан	Тэлмэн	20000
2		Тосонцэнгэл	20000	4		Сонгино	12000
ДҮН			36000		ДҮН		32000
НИЙТ ДҮН					202000		

Хөндлөнгийн хяналт, мониторингийн ажилд орон нутгийн оролцоог хангаж, хамтарч ажиллах ажлын хүрээнд доор дурдсан ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Аймаг, нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын удирдлага, холбогдох албан тушаалтанд ажил, үйлчилгээний зорилго, чиглэлийг танилцуулах:
- Ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажил хийгдэж байгаа сум орон нутгийн удирдлагатай уулзаж ажил, үйлчилгээний зорилго чиглэлийг танилцуулах:
- Хөндлөнгийн хяналт, мониторингийн ажилд аймаг, орон нутгийн холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөлөлтэй хамтарч ажиллах ба орон нутгийн оролцоог хангах:
- Хяналтын тооллогын үйл явцад тухайн аймаг, сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, ойн ангийн төлөөллийг оролцуулж хамтарч ажиллах:
- Ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлын үр дүнг тооцох хяналтын тооллогын ажилд гүйцэтгэгч мэргэжлийн байгууллага, авиа компанийн хариуцсан мэргэжилтэн, инженер техникийн ажилчдын оролцоог хангаж ажиллах:
- Ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажлын гүйцэтгэлийн актыг гүйцэтгэгч аж ахуйн нэгж тус бүрд засаг захиргааны нэгж тус бүрээр гаргаж баталгаажуулах: (Хяналтын акт, тэмцлийн ажлын үр дүнг тооцох актын загварыг тендерийн баримт бичигт хавсаргав).
- Хяналтын хуудасны агуулгад Ойн газраас томилогдсон төслийн менежер болон гүйцэтгэгч талууд санал зөвшилцсөний үндсэн дээр өөрчлөлт оруулж болно.

Ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа хийх, хөнөөлт шавжтай тэмцэх ажлын арга зүй, тэмцлийн ажлын арга хэлбэрийг судалж дүгнэлт гаргах, цаашид ажлын чанар үр дүнг нэмэгдүүлэх, дээшлүүлэх талаар зөвлөмж боловсруулж захиалагчид хүргүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийнэ. Үүнд:

- Ойн хөнөөлт шавж өвчинтэй тэмцэж буй ажлын арга зүй нь ойн санд хөнөөл учруулж буй төрөл зүйлийн хэт олширлыг бууруулж экологийн тэнцвэрт байдлыг хадгалж байгаа эсэх талаар судалгаа хийж зөвлөмж боловсруулж захиалагчид хүргүүлэх.
- Ойн хөнөөлт шавж өвчинтэй тэмцэж буй ажлын хэлбэр нь хөнөөлт шавжийн тоо толгойг бууруулахаас гадна биологийн төрөл зүйлд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэх талаар судалгаа хийж зөвлөмж гаргах.
- Ойн хөнөөлт шавж өвчинтэй тэмцэж буй ажлын арга хэлбэрийг сайжруулах, өөрчлөх боломж байгаа эсэх талаар зөвлөмж боловсруулж захиалагчид хүргүүлэх.

Ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажлын биелэлтийг гаргах, дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлийн тайланг захиалагчид хүлээлгэн өгөх ажлын хүрээнд дараах ажлыг хийнэ. Үүнд:

- Ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажлын биелэлтийг гаргаж дүн шинжилгээ хийж тайлан боловсруулах.
- Ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажлын гүйцэтгэлийн актыг орон нутгийн эрх бүхий албан тушаалтнаар батлуулж тайланд хавсаргах.

- Ажил гүйцэтгэх төлөвлөгөө, ажил гүйцэтгэх үе шатны ажлын хуваарийн дагуу явцын болон гүйцэтгэлийн тайлан боловсруулж захиалагчид хүргүүлнэ.
- Ойн хөнөөлт шавж, өвчний хээрийн судалгаа, тэмцлийн ажилд хяналт мониторинг хийх ажлын явцын болон гүйцэтгэлийн мэдээг дүрс бичлэг, гэрэл зураг хэлбэрээр тухайн орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл цахим сошиал сувгаар болон захиалагч байгууллага Ойн газрын хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэнд тогтмол мэдээ өгнө.